


Биндэр сумын засаг даргын 2025 оны 04 дугаар сарын 30-ний
өдрийн 1/4 захирамжийн 1 дүгээр хавсралт



БИНДЭР СУМЫН 2025 ОНД ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАВРЫН
ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛ, ВАКЦИНЫ ХУВААРЬ

Биндэр

2025.04.21

№	ААНэгж	Хамрагдах мал		Шаардлагатай вакц		Хайрцаг	Шил	Олгогдсон шатахууны зардал /төг/
		Үхэр	нийт	Тун	литр			
1	Бургаст бүрд	3848	3848	3800	7.6	1	13	100000
2	Баттун	3840	3840	3800	7.6	1	13	125000
3	Хараат өгөөж	3069	3069	3000	6	1	5	150000
4	Мандалхаан сүрэг	13152	13152	13200	26.4	5	7	300000
5	Дэлүүн нуур	11185	11185	11200	22.4	4	12	225000
6	Гансумч	5153	5153	5200	10.4	2	2	100000
Нийт дүн		40247	40247	40200	80.4	14	52	1000000

ХУВААРЬ ГАРГАСАН: МЭТ-ИЙН УЛСЫН БАЙЦААГЧ 
ХЯНАСАН: МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ГЭЛЭГЖАМЦ
Х.МЯГМАРБАТ



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/68

Биндэр сум

Гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны А/125 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны А/234 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын арга хэмжээнд сумын нутаг дэвсгэрт байгаа бүх үхэр, гахайг хамруулан 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д даалгасугай.

2.Дархлаажуулалтын хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирлуудад, шаардагдах вакциныг татан авч хуваарилах, заавар, арга зүйгээр хангаж ажиллахыг тархвар зүйч (Ц.Цогтбаатар)-т, ажлын явц, вакцины зориулалт гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д үүрэг болгосугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж, тарилгын хашаа хоолойг малчдаар бэлтгүүлэх, өөрийн багийн нутаг дэвсгэрт байгаа малчдад зар хүргэж бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д үүрэг болгосугай.

5. Мал эмнэлгийн урьчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах 1,000,000 төгрөгний зардлыг Засаг даргын тамгын газраас гаргахыг нягтлан бодогч (Г.Амгаланцэцэг)-д зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (М.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН